“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2019 оны 06 дугаар сарын 21 — Багануур дүүрэг

| Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Зорилт | Үйл ажиллагаа | Хариуцах байгууллага | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Гүйцэтгэл, хувь | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 8 |
| НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ – ӨРХ БҮРД | | | | | | | |
| 1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 1.1.1.4 Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ. | 1.5. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ. | 1.5.1. ХЕТ, инженерийн дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлэн хүлээн авах | БХБЯ<br>БҮТП ОНӨТҮГ<br>“Мон-Энержи Консалт” ХХК | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 50% | |
| | | 1. Ерөнхий төлөвлөлтийг БХБЯ-ны шийдвэрээр Нийслэлийн ИТХ-р хэлэлцүүлэхээр Мон-Энержи Консалт ХХК нь нийслэлийн барилга төлөвлөлтийн газарт материалыг хүргүүлээд байна.<br><br>2. Мон-Энержи Консалт ХХК нь холбоо, дулаан, цэвэр бохир усны зураг төсөлд болон хот хоорондын төв магистрал шугам, уурхай хүртэлх засмал зам, төмөр замын хөндлөн огтлох замуудын трасст холбогдох байгууллагуудаас саналыг авч байна.<br><br>3. БҮТП-ийн зураг төслийн ажлыг эрчимжүүлэхээр БХБЯ, ЭХЯ, УУХҮЯ, БХТ – д албан бичиг хүргүүлэн, уулзалт зохион байгуулж, хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар БХБЯ нь ХХААХҮЯ-аас өмнөх ТЭЗҮ-ийг авч цахилгаан хангамжтай холбоотой материалыг ЭХЯ-д хүргүүлж, техникийн нөхцөл авах талаар ажиллаж байна. | | | | | |
| | | 1.5.2. Багануур ҮТП-ийн дэд бүтцийн | БҮТП | Үйл ажиллагааны | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг боловсруулж дээд шатны байгууллагуудад хүргүүлэх | ОНӨТҮГ | хэрэгжилт хувиар | 100% | 50% | |
| | | 1. “МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодотголд паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг 2019-2021 онуудад тусгуулах тухай саналаа Үндэсний хөгжлийн газарт холбогдох материалуудын хамт 19 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2. УУХҮЯ-аас Үндэсний хөгжлийн газарт Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг Засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодотголоор оруулж санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар албан ёсны хүсэлт тавьсан.<br>3. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд паркийн зүгээс 11 төсөл арга хэмжээний саналыг тусгаж хүргүүлсэн.<br>4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдэх арга хэмжээнд Паркийн цахилгаан хангамжийн ө.х шугам дэд станц барих болон хүнд ба хөнгөн үйлдвэрлэлийн бүсүүдийн дэд бүтцийг байгуулах төслийн хөрөнгийг тусгуулахаар саналыг БХБЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ-дад хүргүүлсэн. | | | | | |
| | | 1.5.4. Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 50% | |
| | | 1. Паркийн дэргэд Эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, инкубатор төв /ЭШСИИТ/ -ийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр ШУТИС, ХААИС, ШАУИС болон УХЭШХ, ЕБСБХ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах дунд хугацааны гэрээ болон Санамж бичиг байгуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>2. Биотехнологийг хөгжүүлэх ажлын хүрээнд 2 удаа эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллүүдтэй хамтран “Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт сургалт, зөвлөгөөн явуулсан. Мөн Хөх нуурын био станц, Хэрлэн Баян-Улааны плантацийг үзэж туршлага судалсан. | | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3. БҮТП-ийн Эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, инкубатор төв /ЭШСИИТ/ -ийн танилцуулга болон паркуудын тулгамдсан асуудлаар НШУҮИГ-т зохион байгуулсан Нийслэлийн паркуудын уулзалт, зөвлөгөөнд оролцсон.<br><br>4. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох гэсэн заалтын хүрээнд дүүргийн ЖДҮДТ–тэй хамтран ажиллах Санамж бичиг байгуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br><br>5. Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан” байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд инновацийн төсөл сонгон шалгаруулалт зарласан. Багануур ҮТП-ийн зүгээс 5 төсөл хүргүүлсний үр дүнд Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр, Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр гэсэн 2 инновацийн төсөл нэг, хоёрдугаар шатны шалгаруулалтад тэнцсэн. Одоогийн байдлаар эцсийн шалгаруулалтад оролцохоор бэлтгэл ажлыг хангаж байна. | | |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МИЧИД-ЭРДЭНЭ